



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/539

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алтаргана 2024” олон улсын XV их наадмын Хурдан азарга, соёолон, дааган насны түрүүг байлах шагналд шаардагдах техникийн тодорхойлолтод заагдсан 3 ширхэг мотоциклийг худалдан авахад 8,400,000 (найман сая дөрвөн зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Мотоциклийн нийлүүлэгчээр “Ууган ундрам” ХХК-ийг сонгож гэрээ шууд байгуулан, барааны нийлүүлэлт, гүйцэтгэлд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д даалгасугай.

3.Гэрээнд заагдсан барааг холбогдох хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд чанартай нийлүүлэхийг “Ууган ундрам” ХХК-ийн захирал (Д.Батмөнх)-д үүрэг болгосугай.

4.Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт сангаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

6324010700